



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/651

Булган сум

**Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.2, 33 дугаар зүйл 33.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны ээлжит X хуралдааны Х/74 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт өвс, тэжээл, хужир, давс бэлтгэн биотехникийн арга хэмжээ зохион байгуулж ажиллах Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд 10,000,000 (арван сая) төгрөг, Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд 10,000,000 (арван сая) төгрөгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлж нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээнд хяналт тавьж, хамтран ажиллах гэрээ байгуулахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр), хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа (Д.Эрдэнэбат), Хөгнө-Тарнын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа (Б.Гончиг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх ажилд шаардагдах 20,000,000 (хорин сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Нэн ховор, ховор амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээ авах” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010907

Аймгийн Засаг даргын 2025 оны  
10 дугаар сарын 15 ны/ний өдрийн  
А/651 дугаар захирамжийн хавсралт

Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргаанд  
биотехникийн арга хэмжээнд шаардагдах төсвийн задаргаа

Бараа материалын тооцоо					
д/д	Барааны нэр	Хэмжэх нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Давс	тн	2.8	1,900	5,320,000
2	Тэжээлийн будаа	тн	5.5	800,000	4,400,000
3	Шатахуун	л	88	2,810	247,280
4	Масло	л	1	32,720	32,720
Нийт дүн					10,000,000

Хөгнө-Тарны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд  
биотехникийн арга хэмжээнд шаардагдах төсвийн задаргаа

Бараа материалын тооцоо					
д/д	Барааны нэр	Хэмжэх нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Боодлын ногоон өвс	ш	534	15,000	8,010,000
2	Бор хужир	тн	4	497,500	1,990,000
Нийт дүн					10,000,000